

Монгол Улсын бэлчээрийг хамгаалах зохистой ашиглахад чиглэсэн тогтвортой менежментийг толовшүүлэх замаар малчдын амьжиргааг дээшлүүлэх, ходоогийн хогжлийг хангах зорилго бүхий Монголын Бэлчээрийн Менежментийн Холбооны гишүүдийн анхдугаар Их хурал Улаанбаатар хотноо 2010 оны 1 дүгээр сарын 11-нд боллоо.

Анхдугаар Их Хуралд нийт 9 аймгийн 55 сумыг толоолсон малчид, эрдэм шинжилгээний байгууллагуудын толоолол оролцож малчин, бэлчээрийн зохион байгуулалттай холбоотой асуудлыг шүүн хэлэлцээд Монгол Улсын Их Хурал, Засгийн Газар, Аймаг, орон нутгийн захиргаа, нийт малчид, олон нийтэд хандан зовломж. уриалга гаргалаа.

Монгол Улсын Их Хурал, Засгийн Газар, Аймаг, орон нутгийн захиргаа, нийт малчдад хандан дараах Зөвлөмжийг гаргаж байна. Үүнд:

Нэг. Монгол Улсын Их Хурал, Засгийн газарт:

- 1.1. Монголын Бэлчээрийн Менежментийн холбооноос боловсруулсан “Бэлчээрийн тухай” хуулийн төслийг хвлээн авч олон нийтийн хэлэлцүүлэг зохион байгуулах, ойрын вед оргон барьж батлуулах,
- 1.2. Газрын асуудал эрхэлсэн торийн захиргааны болон мэргэжлийн байгууллагуудын хариуцах ажлын чиг үүргийг тодорхой болгох,
- 1.3. Бэлчээрийн хяналт, шинжилгээ, үнэлгээний нэгдсэн систем бий болгох,
- 1.4. Бэлчээр ашиглагчдын үндэсний чуулганыг 4 жил тутамд зохион байгуулах ажлыг малчид, ТББ-тай хамтран хэрэгжүүлж байх,
- 1.5. Малчдын оорийгоо удирдах байгууллагад бэлчээрийн харилцааны талаарх эрх хэмжээ олгох, тус байгууллагын тогтолцоог бэхжүүлж чадавхижуулах,
- 1.6. Аймаг дундын отрын нооц нутгийн тоог нэмэгдүүлэн хамгаалалтын болон бусад зохион байгуулалтын арга хэмжээг авах,
- 1.7. Уул уурхай, ашигт малтмал олборлолтын газрын зовшоорлийг олгохдоо малчдын саналыг авах, бэлчээрийг нохон сэргээх, сайжруулахтай холбогдсон толборийг урьдчилан авч тусгай сан байгуулан бэлчээр сайжруулахад ашиглах захиран зарцуулах арга хэмжээг журамлах,
- 1.8. Орон нутагт малын гаралтай бүтээгдэхүүн боловсруулах жижиг, дунд вйлдвэр байгуулахад бодитой дэмжлэг үзүүлэх,

Хоёр. Аймаг, орон нутгийн захиргаанд:

2.1. Сум, аймагт малчдын сайн дурын Бэлчээр ашиглагчдын хэсэг БАХ, сумын бэлчээр ашиглагчдын холбоо СБАХ, аймгийн бэлчээр ашиглагчдын холбоог АБАХ зохион байгуулах вйл ажиллагааг нь дэмжиж ажиллах,

2.2. Малын гаралтай тvvхий эд худалдан авах борлуулалтын системийг боловсронгуй болгох,

2.4 Бэлчээрийн даацад тохируулан малын тоо хэмжээг зохицуулах, хязгаарлах талаархи торийн бодлогыг орон нутагт хэрэгжvvлэх,

Гурав. Бэлчээр ашиглагч малчид, мал бvнхий байгууллага, иргэдэд:

3.1. Амьжиргааны vндсэн эх vүсвэр болсон бэлчээрээ хамгаалах, зов менежмент нэвтрvvлэх зорилгоор нутаг дэвсгэрт vндэслэгдсэн малчдын хамтын нийгэмлэгийн зохион байгуулалтанд хамрагдах,

3.2. Бэлчээрийн талхагдал, хорсний доройтлыг сааруулах vүднээс бэлтгэлийн насны эр малыг эдийн засгийн эргэлтэнд оруулахыг эрмэлзэх, малын торол хоорондын зохистой харьцааг баримтлан сvргийн чанар, бvтцэд илvv анхаарч бэлчээрийн даац, ачааллыг зохицуулах,

3.3. Тvvхий эд, нэмvv ортог шингэсэн бvтээгдэхvвнийг (бэлтгэлийн стандартын дагуу ангилан ялгаж бэлтгэсэн) зохион байгуулалттайгаар бэлтгэн завсрын дамжлагагvйгээр ХАА-н бирж болон vндэсний боловсруулах вйлдвэрvүдэд нийлvvлэх,

3.4. Уур амьсгалын оорчлолт, нийгмийн хогжлийн чиг хандлагатай уялдуулан мал аж ахуй эрхэлж ирсэн уламжлалт арга барилаа боловсронгуй болгох, дэвшилт технологи нэвтрvvлэх,

Монголын Бэлчээрийн Менежментийн Холбооны анхдугаар Их Хурлын толоологчид

МОНГОЛЫН БЭЛЧЭЭРИЙН МЕНЕЖМЕНТИЙН ХОЛБООНЫ АНХДУГААР ИХ ХУРЛААС ОЛОН НИЙТЭД ХАНДАН ГАРГАСАН УРИАЛГА

2010 оны 1 дvгээр сар 12 Улаанбаатар хот

Цаг уурын эрс оорчлолт, цолжилт, бэлчээрийн доройтол нь Монгол улсын нийгэм, эдийн засаг, соёлын салшгvй хэсэг болж хэдэн мянган жил уламжлагдан хадгалагдаж ирсэн нvүдлийн мал аж ахуйг эрхлэхэд ихээхэн эрсдэлтэй болгож ходоогийн ядуурлыг

гүнзгийгүүлж байгааг иш үндэс болгон Монголын Бэлчээрийн Менежментийн Холбооны анхдугаар Их хурлаас нийт малчид, иргэд, УИХ, Засгийн газар, иргэний нийгмийн байгууллагуудад хандан доорхи УРИАЛГЫГ сонордуулж байна.

Зах зээлийн нохцолд мал аж ахуйн салбарын оршин тогтнох үндэс болсон бэлчээрийг зов зохистой ашиглах, хамгаалах бүтэц зохион байгуулалтыг бүрдүүлэх, ирээдвйн сайн сайхан амьдралыг цогцлуулахын тулд малчин айл орхвуд нутаг дэвсгэрт үндэслэгдсэн зохион байгуулалтын шинэ хэлбэрт орж сайн дураараа эвлэлдэн нэгдэцгээе.

Энэхүү зохион байгуулалтыг бүхий л талаар дэмжин ажиллах зорилготой ажиллаж байгаа Монголын Бэлчээрийн Менежментийн Холбоонд гишүүнээр элсэн үйл ажиллагаа, дуу хоолойгоо нэгтгэцгээе.

Мал аж ахуйн салбарыг тогтвортой хөгжүүлэх, бэлчээрийн доройтлыг сааруулах, зах зээлийн нохцолд нийцсэн бэлчээрийн менежментийг толовшуулэх үүднээс бэлчээрийг зүй зохистой эзэмших, ашиглах, хамгаалахад чиглэгдсэн эрх зүйн орчинг бүрдүүлэхэд нэн шаардлагатай бэлчээр ашиглалтын уламжлалт арга хэлбэрт үндэслэгдсэн "Бэлчээрийн тухай" хуулийг ойрын үед батлан гаргая.

Бэлчээрийн газрыг хэн дуртайд нь лиценз нэрээр олгож, байгаль орчныг дураараа сүйтгэдэг, ухаж тонхдог, нохон сэргээлтийг умартдаг, оволжоо, бууц бусниулдаг, мал хулгайлдаг, гол, горхи бохирдуулдаг бусармаг бүхэнтэй тэмцэхэд хүчээ нэгтгэцгээе.

Цаг агаарын хүндрэлээс үүдэн ходоогийн айл орх, хүн мал зуданд нэрвэгдэж байгаа энэ хэцүү үед халуун сэтгэл гарган малчин түмэндээ тусламжын гараа сунгаж, хамтын хүчээр энэ бэрхшээлийг даван туулахад нийт ард иргэд, төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, хамт олон нэгдэн нягтарч, эх оронч санал, санаачилга гаргахыг уриалж байна.

ХУРАЛД ОРОЛЦОГСОД